

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12 Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	8
4. Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
САНГИЙН ЗАХИРАЛ Х.ГАНБААТАР
ТАНАА

2020.03.13 № 06/875
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сангийн захирал Х.Ганбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардлын болон балансын данстай холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Лидер экаунт аудит” ХХК-ийн аудитор Э.Учралзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Лидер экаунт аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэлийг аудитад ашиглах аргачлал зөвлөмжийг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрхэм зорилго:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн төлөв байдлыг судлан тогтоох, байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, иргэдэд экологийн боловсрол олгох чиглэлээр сангийн хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулахад оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгалийн баялагийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг судлан тогтоох, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, иргэдэд экологийн боловсрол олгох, байгаль орчныг хамгаалахтай холбогдсон асуудлаар үндэсний болон олон улсын хурал уулзалт зохион байгуулах, байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, байгаль орчныг хамгаалах, хянах, судлахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, уур амьсгалын сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “ACOLOUS” программ хангамж ашигладаг байна.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Байгаль орчин, уур амьсгалын сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 752,080.0 мянган төгрөгөөс тооцон 11,281.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 59,764.4 мянган төгрөгөөр тооцсон нь төсөвт байгууллагад санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үед голчлон төсвийн зарцуулалтыг авч үздэгтэй холбоотой болно.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,237.9 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	27,538.1	30,257.7	2,719.6
Үндсэн хөрөнгө	20,378.9	16,421.4	(3,957.5)
Нийт хөрөнгө	47,917.0	46,679.1	(1,237.9)
Өглөг	279,204.3	54,417.9	(224,786.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	(231,287.3)	(7,738.8)	(223,548.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	47,917.0	46,679.1	(1,237.9)

Бараа материалын дансны үлдэгдэл 2,719.6 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд 22,699.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,957.5 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл байна.

2014 онд үүссэн 6 аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой 54,417.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд тус сангаас улсын төсөвт төвлөрүүлсэн 166,289.2 мянган төгрөгийн орлогын 91,284.5 мянган төгрөг нь нөхөн төлбөр, 29,919.6 мянган төгрөг нь үнэт цаас, 28,073.6 мянган төгрөг нь гэрчилгээний үнэ, 17,011.5 мянган төгрөг нь эрхийн бичиг, тэмдэгтийн хураамж болон бусад орлого байна. Орлого өмнөх оныхоос 327,590.0 мянган төгрөгөөр буурсан нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого буурсантай холбоотой байна.

Байгаль орчин, уур амьсгалын санд тайлант онд 1,881,878.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 1,756,189.3 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, 125,689.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нэмэлт санхүүжилтээр 2,214,097.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, үүнээс 2,080,267.3 мянган төгрөгийг зарцуулж, 133,830.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж, нийт 9 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 54,552.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 54,417.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 134.3 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлэв.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал гараагүй болно.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, уур амьсгалын сангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 135 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хувь хүний орлогын албан татварын талаар

3.2.1 Илрүүлэлт:

- Хувь хүний орлогын албан татварыг тооцохдоо нийгмийн даатгалын шимтгэлийг 134.3 мянган төгрөгөөр дутуу тооцоолж, тайлагнасан нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, ... албан татварыг холбогдох төсөвт төлнө”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д “Ажил олгогч нь, хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, цаг хугацаанд нь төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

- Стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

- Цалин хөлсний программын тооцооллын алдааг засах, Хувь хүний орлогын албан татварын зөрүүг хүн нэг бүрээр хийж, татварын тайланг залруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,095,465,270.36	471,189,075.00
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
3121	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	(0.00)	(0.00)
33	АВЛАГА	1,067,927,119.36	440,931,348.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	1,067,927,119.36	436,931,348.00
335	Бусад авлага	-	4,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	4,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,538,151.00	30,257,727.00
354	Хангамжийн материал	27,538,151.00	30,257,727.00
35410	Бичиг хэргийн материал	-	46,350.00
35420	Аж ахуйн материал	27,538,151.00	28,162,977.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,048,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,378,869.90	16,421,374.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,378,869.90	16,421,374.60
392	Биет хөрөнгө	19,478,869.90	15,701,374.60
39203	Авто тээврийн хэрэгсэл	11,409,752.91	11,409,752.91
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,281,950.60)	(3,422,925.90)
39205	Машин, тоног төхөөрөмж	4,135,000.00	4,135,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,586,166.78)	(3,413,166.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,522,200.00	14,522,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,719,965.63)	(7,529,485.59)
393	Биет бус хөрөнгө	900,000.00	720,000.00
39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хасагдуулга	-	(180,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,115,844,140.26	487,610,449.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	279,204,278.00	54,417,990.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	279,204,278.00	54,417,990.00
413	Өглөг	279,204,278.00	54,417,990.00
4136	Бусад өглөг	279,204,278.00	54,417,990.00
41361	Байгууллагад төлөх өглөг	279,204,278.00	54,417,990.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	836,639,862.26	433,192,459.60
51	Засгийн газрын хувь оролцоо	836,639,862.26	433,192,459.60
512	Хуримтлагдсан үр дүн	836,639,862.26	433,192,459.60
51210	Өмнөх үеийн үр дүн	836,639,862.26	836,639,862.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	(403,447,402.66)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,115,844,140.26	487,610,449.60

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,837,115,108.80	3,467,536,669.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	493,879,229.44	166,289,247.96
120	Нийтлэг татварын бус орлого	493,879,229.44	166,289,247.96
120009	Бусад орлого	493,879,229.44	166,289,247.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,343,235,879.36	3,301,247,421.94
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,740,473,790.00	1,881,878,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,740,473,790.00	1,881,878,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,602,762,089.36	1,419,368,921.94
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	2,602,762,089.36	1,419,368,921.94
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	4,805,597,791.10	3,870,984,072.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,060,725,504.30	3,570,733,388.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,060,725,504.30	3,570,733,388.30
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	106,309,189.00	156,898,849.00
210101	Цалин	25,345,508.00	67,708,669.00
210102	Нэмэгдэл цалин	74,360,681.00	81,349,380.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,603,000.00	7,840,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,517,964.00	19,562,979.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	5,917,564.00	15,962,579.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	900,100.00	900,100.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	720,100.00	720,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	180,000.00	180,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,800,200.00	1,800,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,919,000.00	89,567,869.00
210301	Гэрэл цахилгааны зардал	1,353,000.00	2,131,750.00
210304	Байрны түрээс	88,566,000.00	87,436,119.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,607,212.00	26,073,552.00
210401	Бичиг хэргийн материал	2,641,412.00	7,087,224.00
210402	Тээвэр, шатахууны зардал	4,445,800.00	7,099,220.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	5,520,000.00	11,887,108.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,347,300.00	36,367,900.00
210601	Багаж хэрэгсэл	-	9,622,200.00
210602	Тавилга	-	6,030,000.00
210604	Урсгал засвар	7,347,300.00	20,715,700.00
2107	Томилолт, зочны зардал	614,400.00	9,214,600.00
210702	Дотоод томилолтын зардал	614,400.00	9,214,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,663,250,282.00	3,149,590,345.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,662,854,282.00	3,149,053,777.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	396,000.00	359,568.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	177,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	171,160,157.30	83,457,294.30
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	167,382,662.00	79,499,799.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,777,495.30	3,957,495.30

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,744,872,286.80	300,250,684.26
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,744,872,286.80	300,250,684.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,744,872,286.80	300,250,684.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	31,517,317.70	(403,447,402.66)
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	31,517,317.70	(403,447,402.66)

СТ-3А

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,837,115,108.80	4,535,463,789.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	493,879,229.44	166,289,247.96
120	Нийтлэг татварын бус орлого	493,879,229.44	166,289,247.96
120009	Бусад орлого	493,879,229.44	166,289,247.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,343,235,879.36	4,369,174,541.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,740,473,790.00	1,881,878,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,740,473,790.00	1,881,878,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,602,762,089.36	2,487,296,041.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	2,602,762,089.36	2,487,296,041.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	4,837,115,108.80	4,535,463,789.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,837,115,108.80	4,535,463,789.26
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,092,242,822.00	3,798,281,757.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	106,309,189.00	156,898,849.00
210101	Үндсэн цалин	25,345,508.00	67,708,669.00
210102	Нэмэгдэл	74,360,681.00	81,349,380.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,603,000.00	7,840,800.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	9,517,964.00	19,562,979.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	5,917,564.00	15,962,579.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	900,100.00	900,100.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	720,100.00	720,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	180,000.00	180,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,800,200.00	1,800,200.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	89,919,000.00	89,567,869.00
210301	Гэрэл цахилгааны зардал	1,353,000.00	2,344,925.00
210304	Байрны түрээс	88,566,000.00	87,222,944.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,902,025.00	25,909,978.00
210401	Бичиг хэрэг	4,936,225.00	6,923,650.00
210402	Тээвэр, шатахуун	4,445,800.00	7,099,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,520,000.00	11,887,108.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,347,300.00	42,694,900.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	9,622,200.00
210602	Тавилга	-	6,030,000.00
210604	Урсгал засвар	7,347,300.00	27,042,700.00
2107	Томилолт, зочны зардал	614,400.00	9,214,600.00
210702	Дотоод албан томилолт	614,400.00	9,214,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,696,250,282.00	3,370,932,783.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	2,695,854,282.00	3,370,396,215.00
210803	Даатгалын үйлчилгээ	396,000.00	359,568.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	177,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,382,662.00	83,499,799.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	167,382,662.00	79,499,799.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,744,872,286.80	737,182,032.26
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,744,872,286.80	737,182,032.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,744,872,286.80	737,182,032.26
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

СТ-4А

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	-	-
C08	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	836,639,862.26	836,639,862.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	836,639,862.26	836,639,862.26
D04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
D05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(403,447,402.66)	(403,447,402.66)
D09	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	433,192,459.60	433,192,459.60

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,881,878.500.00	1,756,189,250.00	125,689,250.00	93.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,881,878.500.00	1,756,189,250.00	125,689,250.00	93.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,881,878.500.00	1,756,189,250.00	125,689,250.00	93.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,012,400.00	89,190,180.00	822,220.00	99.1
210101	Үндсэн цалин	90,012,400.00	89,190,180.00	822,220.00	99.1
210102	Нэмэгдэл	82,171,600.00	81,349,380.00	822,220.00	99.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,840,800.00	7,840,800.00	-	100.0
210104	Урамшуулал			-	
210105	Гэрээт ажлын хөлс			-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,251,500.00	11,088,122.00	163,378.00	98.6
210201	Тэтгэврийн даатгал	7,651,100.00	7,487,722.00	163,378.00	97.9
210202	Тэтгэмжийн даатгал	900,100.00	900,100.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	720,100.00	720,100.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	180,000.00	180,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,800,200.00	1,800,200.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,123,500.00	89,567,869.00	1,555,631.00	98.3
210301	Гэрэл, цахилгаан	2,558,100.00	2,344,925.00	213,175.00	91.7
210302	Түлш, халаалт			-	
210303	Цэвэр, бохир ус			-	
210304	Байрны түрээс	88,565,400.00	87,222,944.00	1,342,456.00	98.5
2104	Хангамж, бараа материалын зардал	18,240,000.00	17,920,610.00	319,390.00	98.3
210401	Бичиг хэрэг	5,821,200.00	5,808,200.00	13,000.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	6,890,400.00	6,799,220.00	91,180.00	98.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,528,400.00	5,313,190.00	215,210.00	96.1
210404	Ном, хэвлэл			-	
2105	Нормативт зардал			-	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,493,900.00	10,478,600.00	15,300.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл			-	
210604	Урсгал засвар	10,493,900.00	10,478,600.00	15,300.00	
2107	Томилолт, зочны зардал	9,217,800.00	9,214,600.00	3,200.00	100.0
210701	Гадаад албан томилолт			-	
210702	Дотоод албан томилолт	9,217,800.00	9,214,600.00	3,200.00	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			-	

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,651,539,400.00	1,528,729,269.00	122,810,131.00	92.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,650,796,900.00	1,528,192,701.00	122,604,199.00	92.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			-	
210803	Даатгалын үйлчилгээ			-	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	177,000.00	21,000.00	89.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			-	
210806	Даатгалын үйлчилгээ	396,000.00	359,568.00	36,432.00	90.8
210807	Тээврийн хэрэгслийн оношлогоо	148,500.00		148,500.00	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,881,878,500.00	1,756,189,250.00	125,689,250.00	93.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,881,878,500.00	1,756,189,250.00	125,689,250.00	93.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,881,878,500.00	1,756,189,250.00	125,689,250.00	93.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	7	7		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	5		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4		
620003	Үйлчлэх ажилтан				
620004	Гэрээт ажилтан				
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2	2		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2		
650010	Гэрээт ажилтан				

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,214,097,906.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,214,097,906.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,080,267,353.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,708,669.00
210101	Үндсэн цалин	67,708,669.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,474,857.00
210201	Тэтгэврийн даатгал	8,474,857.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,989,368.00
210401	Бичиг хэрэг	1,115,450.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,573,918.00
2105	Эд хогшил худалдан авах	32,216,300.00
210501	Багаж, техник, хэрэгсэл	9,622,200.00
210502	Тавилга	6,030,000.00
3210503	Урсгал засвар	16,564,100.00
2107	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,884,378,360.00
210701	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,884,378,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,499,799.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79,499,799.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	133,830,553.36
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	133,830,553.36
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	133,830,553.36
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,214,097,906.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,214,097,906.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,214,097,906.36
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.12.31			САГ-2020/15/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Байгаль орчин, уур амьсгалын сан		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хувь хүний орлогын албан татварыг тооцохдоо нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу тооцсон.	134.3	Зөвлөмж	Захирал	Х.Ганбаатар
				Ерөнхий нягтлан бодогч	Г.Одончимэг
Дүн		134.3			

[illegible]

[illegible]

[illegible]